



Ernst & Young Mongolia Audit LLC  
Suite 200, 8 Zovkhis Building  
Seoui Street 21  
Ulaanbaatar 14251  
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005  
Fax: +976 11 312042  
ey.com

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Улаанбаатар БҮК ХК-н Хувьцаа эзэмшигчдэд

Бид Улаанбаатар БҮК ХК (цаашид Компани гэнэ), 2014 оны 12 сарын 31-ний өдрөөрхи Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь Компанийн захирлын хариуцлага байдаг.

### Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрдслийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.



Building a better  
working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Улаанбаатар БҮК ХК-н Хувьцаа эзэмшигчдэд

---

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон Компанийн санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

*Ernst & Young Mongolia Audit LLC*

Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 08 JUN 2015

Петр Марки  
Захирал